



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 1/29

Ховд

Г Орон тооны зохицуулалтын тухай Г

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэцэд санхүү албаны дарга /сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч/, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, сумын орон нутгийн байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогчийн орон тоотой байхаар тогтоосугай.

2. Төсвийн хэрэгжилтийг хангахад хяналтыг сайжруулж, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажлын ачаалалыг жигдрүүлэхээр сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад ажиллуулах нягтлан бодогчдын орон тоог 1 дүгээр хавсралтаар, сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллуулах нягтлан бодогчдын орон тоог 2 дугаар хавсралтаар, Жаргалант сумын цэцэрлэгүүдэд шинээр нэмж ажиллуулах нягтлан бодогч, няравын орон тоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус захирамжийн 1 дүгээр хавсралтад заасан сумдын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчдод сумын цэцэрлэгийн нягтлан бодогчийн ажлыг хөдөлмөрийн гэрээгээр хавсран гүйцэтгүүлж сар бүр албан тушаалын цалингийн 20,0 хүртэл хувиар албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгохыг сумдын цэцэрлэгийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Тус бүтцийн өөрчлөлтөөр шинээр ажиллах орон тооны цалингийн сан болон хөдөлмөрийн гэрээгээр ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг байгууллагын 2019 оны батлагдсан төсвийн цалингийн санд багтаан шийдвэрлэж ажиллахыг сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчид болон Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт тус, тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн 1 дүгээр заалтаар шинэчлэн тогтоож буй сумын санхүүгийн албаны бүтэцийн орон тооноос илүү гарсан одоо ажиллаж буй санхүү нягтлан бодогчдыг сумын Ерөнхий боловсролын сургууль болон эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчоор шилжүүлэн ажиллуулахыг сумдын Засаг дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарт, байгууллагуудад шинээр авах нягтлан бодогчдыг Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зөвшилцөн томилохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/, сумдын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Жаргалант сумын цэцэрлэгүүдийн эрхлэгч нарт тус, тус даалгасугай.

6.Орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор байгууллагуудад бүтэц орон тоо, цалингийн сангийн талаар мөрдөж буй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хяналт, үзлэгийг зохион байгуулан дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга /М.Пүрэвхүү/, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

7.Тус захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо батлах тухай" А/638 дугаар захирамжийн хавсралтын 1, 2 дугаар зүйлийн 4-7 дугаарт заасан албан тушаалуудыг "Сумын санхүү албаны дарга /сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч/, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, сумын орон нутгийн байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогч" гэж, 3 дугаар зүйлийн 7 дугаарт заасан албан тушаалыг "Сумын орон нутгийн байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогч" гэж тус тус өөрчилсүгэй.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/129 дүгээр захирамжийн
1 дүгээр хавсралт

СУМДЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ /ЦЭЦЭРЛЭГ/-ИЙН
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЛБАН ТУШААЛД АЖИЛЛУУЛАХ
ОРОН ТООНЫ ЖАГСААЛТ

№	Нэрс	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Алтай	Нягтлан бодогч	1
2	Буянт	Нягтлан бодогч	1
3	Дарви	Нягтлан бодогч	1
4	Дөргөн	Нягтлан бодогч	1
5	Дуут	Нягтлан бодогч	1
6	Зэрэг	Нягтлан бодогч	1
7	Манхан	Нягтлан бодогч	1
8	Мөст	Нягтлан бодогч	1
9	Мөнххайрхан	Нягтлан бодогч	1
10	Мянгад	Нягтлан бодогч	1
11	Үенч	Нягтлан бодогч	1
12	Ховд	Нягтлан бодогч	1
13	Цэцэг	Нягтлан бодогч	1
14	Чандмань	Нягтлан бодогч	1
15	Эрдэнэбүрэн	Нягтлан бодогч	1
Нийт			15

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/129 дүгээр захирамжийн
2 дугаар хавсралт

СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД НЯГТЛАН БОДОГЧИЙН
АЛБАН ТУШААЛД АЖИЛЛУУЛАХ ОРОН ТООНЫ ЖАГСААЛТ

№	Нэрс	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Алтай	Нягтлан бодогч	1
2	Буянт	Нягтлан бодогч	1
3	Дарви	Нягтлан бодогч	1
4	Дөргөн	Нягтлан бодогч	1
5	Дуут	Нягтлан бодогч	1
6	Зэрэг	Нягтлан бодогч	1
7	Манхан	Нягтлан бодогч	1
8	Мөнххайрхан	Нягтлан бодогч	1
9	Мянгад	Нягтлан бодогч	1
10	Үенч	Нягтлан бодогч	1
11	Ховд	Нягтлан бодогч	1
12	Цэцэг	Нягтлан бодогч	1
13	Чандмань	Нягтлан бодогч	1
14	Эрдэнэбүрэн	Нягтлан бодогч	1
Нийт			14

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/129 дүгээр захирамжийн
3 дугаар хавсралт

ЖАРГАЛАНТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД НЯГТЛАН БОДОГЧ
БОЛОН НЯРАВЫН АЛБАН ТУШААЛД
АЖИЛЛУУЛАХ ОРОН ТООНЫ ЖАГСААЛТ

№	Нэрс	Албан тушаалын нэр	Орон тоо
1	2 дугаар цэцэрлэг	Нягтлан бодогч	1
2	3 дугаар цэцэрлэг	Нягтлан бодогч	1
3	4 дүгээр цэцэрлэг	Нягтлан бодогч	1
4	7 дугаар цэцэрлэг	Нягтлан бодогч	1
5	9 дүгээр цэцэрлэг	Нягтлан бодогч	1
6	10 дугаар цэцэрлэг	Нягтлан бодогч	1
7	14 дүгээр цэцэрлэг	Нягтлан бодогч	1
Нийт			7
1	1 дүгээр цэцэрлэг	Нярав	1
2	5 дугаар цэцэрлэг	Нярав	1
3	8 дугаар цэцэрлэг	Нярав	1
4	10 дугаар цэцэрлэг	Нярав	1
5	11 дүгээр цэцэрлэг	Нярав	1
6	13 дугаар цэцэрлэг	Нярав	1
7	14 дүгээр цэцэрлэг	Нярав	1
Нийт			7

-оОо-